

Хот төлөвлөлт, судалгааны институтын
Удирдах зөвлөлийн 2025 оны
02 дугаар сарын 12 - ны өдрийн
хурлын .2... тоот тогтоолын хавсралт



ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ – 2025

Улаанбаатар хот
2025 он



**“ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ” ОНӨААТҮГ-ЫН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2025 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г Байгууллагын бизнес төлөвлөгөөг батлах Г
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам”, “Хот төлөвлөлт судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.5, 6.6 хэсэг, 6.8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Байгууллагын эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх 2025 оны зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж, биелэлт үр дүнг удирдах зөвлөлд тайлагнаж ажиллахыг “Хот төлөвлөлт судалгааны институт” ОНӨААТҮГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Р.Амартүвшин)-д үүрэг болгосугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Г.БАТЗОРИГ

Л.ЭРДЭНЭБАТ



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

Хөвсгөл лэйк сити товер-8/1, Багатойруу 1,
8 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14200
Утас/Факс: (976-11) 32 02 48
Цахим хуудас: www.umch.ub.gov.mn

2025.07.29 № 1/1289

танай _____-ны № _____-т

Захирамжийн хэрэгжилтийг ханган
ажиллах тухай

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/921 дүгээр захирамжаар танай байгууллагын 2024 оны эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний биелэлт болон 2025 оны эдийн засгийн зорилтот түвшинг баталсан байна. Дээрх захирамжийн дагуу дараах арга хэмжээ авч ажиллахыг мэдэгдэж байна. Үүнд:

1.2024 оны эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний биелэлт “Бүрэн хангалттай” үнэлэгдсэн тул захирал Р.Амартүвшинд 32,105,670.00 (гучин хоёр сая нэг зуун таван мянга зургаан зуун дал) төгрөгийн урамшууллыг олгох;

2.2025 оны нийт орлогыг 8,349,210,200.00 төгрөг, нийт зардлыг 8,175,493,200.00 төгрөг, ашиг 173,717,000.00 төгрөг, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал 0,96 төгрөг, тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 476,002,300.00 төгрөг байхаар батлагдсан. “Эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилт”-ын дагуу 2025 оны орлого, зардлын сар, улирлын хуваарийг гарган, үйл ажиллагааны менежментийг сайжруулах ажлын төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг ханган ажиллах;

3.Шинээр хийгдэх хөрөнгө оруулалт, шинэчлэлтийн ажил, худалдан авах бараа материалыг нэр төрлөөр нь багцлан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өргийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолыг баримтлан хөрөнгө худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулан, шинээр бий болсон хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авах;

4.Үйлдвэрийн захирал Р.Амартүвшингийн сарын үндсэн цалинг 3,300,000.00 (гурван сая гурван зуун мянга) төгрөг байхаар тогтоосон тул 2025 оны 06 дугаар сарын 01-ны өдрөөс тооцож олгох;

5.Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулах “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г 2025.08.08-ны дотор тус газрын Захиргаа удирдлагын хэлтэст эх хувиар нь хүргүүлэх;

1 дүгээр хавсралт: НЗД-ын 2025 оны А/921 захирамж, 3 хуудастай.

2 дугаар хавсралт: Гэрээ, 8 хуудастай.



Нийслэлийн өмчийн харилцааны газар
Захиргаа
Дарга
Володя Оюумаа
2025.07.30 14:17



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар A/921

Улаанбаатар хот

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой
үйлдвэрийн газруудын захиралтай байгуулсан
2024 оны Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх
зорилтот түвшний биелэлт болон 2025 оны
"Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот
түвшин" батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан Онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээний 2024 оны зорилтот түвшний биелэлтийн дүнг 1 дүгээр, урамшууллын хэмжээг 2 дугаар, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2025 оны зорилтот түвшинг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлын албан тушаалын цалингийн хэмжээг 4 дүгээр хавсралтын дагуу шинэчлэн тогтоосугай.

3.Шинэчилсэн цалинг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож олгохыг байгууллагын нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

4.Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой 18 үйлдвэрийн газрын захиралтай "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ" байгуулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

5.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, орлого, үр дүнг нэмэгдүүлэн, авлага, өр төлбөрийг бууруулж, үйл ажиллагааны менежментийг сайжруулан ажиллахыг орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын захирлуудад үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1725024184

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
 08 дугаар сарын 1-ны өдрийн
 А/92/дүгээр захирамжийн
 3 дугаар хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДЭВЭРИЙН ГАЗРУУДЫН 2025 ОНЫ ЗОРИЛТ

№	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нэрс	Нийт орлого			Нийт зардал			Ашиг алдагдал			Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	Хөрөнгө оруулалт
		2024 оны зорилт	2024 оны гүйцэтгэл	2025 оны зорилт	2024 оны зорилт	2024 оны гүйцэтгэл	2025 оны зорилт	2024 оны зорилт	2024 оны гүйцэтгэл	2025 оны зорилт		
1	Ус сувгийн удирдах газар	130,455,649.9	142,268,464.1	145,692,365.0	133,792,633.8	133,168,449.3	180,359,989.6	(3,336,983.9)	9,100,014.8	(34,667,624.6)	1.24	17,591,400.0
2	Хөрөнгө оруулалтын газар	6,354,836.0	7,468,012.5	10,081,057.2	6,144,153.5	5,631,853.4	9,732,571.8	189,614.3	1,836,159.1	313,636.9	0.97	392,093.8
3	Хот төлөвлөлт, судалгааны институт	4,586,710.6	6,117,048.9	8,349,210.2	4,445,398.2	5,760,319.3	8,175,493.2	141,312.4	356,729.6	173,717.0	0.96	476,002.3
4	Зорчигч тээвэр гурав	53,451,414.6	52,814,452.8	50,126,389.1	60,629,653.3	47,381,431.2	53,258,834.5	(7,178,238.7)	5,453,021.6	(3,132,445.4)	0.90	2,881,336.0
5	Зорчигч тээвэр тав	14,845,403.3	16,793,926.2	41,499,346.3	19,600,996.9	16,587,523.4	45,707,532.8	(4,755,593.6)	206,402.8	4,208,186.5	1.10	279,809.8
6	Зорчигч тээвэр дөрөв	18,125,529.8	15,594,561.7	36,590,100.0	19,359,891.5	12,796,878.6	36,264,670.0	(1,234,361.7)	2,797,683.1	325,400.0	0.99	-
7	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар	139,439,798.5	146,225,622.1	157,028,170.7	159,103,302.3	154,983,427.0	186,747,321	(19,663,503.8)	(8,757,804.9)	29,719,150.3	1.19	10,053,769.9
8	Хүнс хангамж төв	7,881,499.7	7,912,576.4	11,135,363.8	7,854,533.3	7,753,198.6	11,045,353.2	26,966.4	159,377.8	43,450.5	1.00	-
9	Өсвөр үе хүнс	11,465,951.1	12,422,489.3	14,530,287.9	11,457,463.9	12,222,977.9	14,487,070.5	8,487.2	199,511.4	38,895.7	0.99	179,820.0
10	Гэрлэх ёслолын ордон	2,274,386.0	2,087,402.5	2,725,840.0	2,255,550.8	1,894,183.4	2,705,786.1	18,835.2	203,219.0	18,048.48	0.91	1,600,000.0
11	Багачууд хүнс	5,823,002.8	5,497,173.7	1,232,915.07	5,750,800.9	5,311,291.6	1,124,019.0	72,201.9	185,882.2	98,006.4	0.90	88,700.0



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА	3
Ерөнхий танилцуулга.....	3
Бүтэц зохион байгуулалтын ерөнхий схем	4
ХОЁРДУГААР БҮЛЭГ: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ	6
Эрхэм зорилго, чиг үүрэг, алсын хараа, үнэт зүйл, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл	6
ГУРАВДУГААР БҮЛЭГ: 2025 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ	9
ЗОРИЛТ НЭГ: БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫГ ӨМНӨХ ОНЫ ЗОРИЛТООС БУУРУУЛАХГҮЙ БАЙХ	10
ЗОРИЛТ ХОЁР: ЦЭВЭР АШГИЙН ТҮВШИНГ ӨМНӨХ ОНЫ ТӨЛӨВЛӨЛТӨД ДҮЙЦҮҮЛЭХ.....	11
1. Зардлын задаргаа.....	12
1.1 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	13
1.2 Цалингийн зардал.....	13
1.3 Түрээс, ашиглалтын зардал.....	14
1.4 Албан томилолтын зардал	15
1.5 Элэгдлийн зардал.....	15
1.6 Түүхий эд, материалын зардал	16
1.7 Сургалт, зар сурталчилгааны зардал	16
1.8 Эрдэм шинжилгээний зардал	18
1.9 Шуудан холбооны зардал.....	19
1.10 Тээврийн зардал.....	19
1.11 Засвар, үйлчилгээний зардал	19
1.12 Үйл ажиллагааны бус зардал	20
ЗОРИЛТ ГУРАВ: ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ	21
2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
СУДАЛГААНЫ АЖЛЫН ЖАГСААЛТ /Хэлтсүүдээс ирсэн санал/	27



ХҮСНЭГТИЙН ТАЙЛБАР

Хүснэгт 1.	Батлагдсан орон тоо	4
Хүснэгт 2.	Борлуулалтын төлөвлөгөөний биелэлт, сая төг	10
Хүснэгт 3.	2025 оны бизнесийн төлөвлөгөөний төсөл /мянган төгрөгөөр/	11
Хүснэгт 4.	2025 онд төлөвлөсөн зардлын нэгдсэн хүснэгт /мянган төгрөг/	12
Хүснэгт 5.	ББӨ /мянган төгрөг/	13
Хүснэгт 6.	Нийт ажилчидын цалингийн батагдсан төсөв /төгрөг	13
Хүснэгт 7.	Түрээс, ашиглалтын зардал /мянган төгрөг/	14
Хүснэгт 8.	Гэрээний дугаар ННУГБА-23/01/05 -ын задаргаа	14
Хүснэгт 9.	Албан томилолтын зардал /мянган төгрөг/	15
Хүснэгт 10.	Элэгдлийн зардал /мянган төгрөг/	15
Хүснэгт 11.	Түүхий эд, хангамжийн материалын зардал /мянган төгрөг/	16
Хүснэгт 12.	Зар сурталчилгааны зардал /мянган төгрөг/	16
Хүснэгт 13.	Сургалтын зардал /мянган төгрөг/	17
Хүснэгт 14.	Эрдэм шинжилгээ, судалгааны зардал /мянган төгрөг	18
Хүснэгт 15.	Шуудан холбооны зардал /мянган төгрөг/	19
Хүснэгт 16.	Шатахууны зардал /мянган төгрөг/	19
Хүснэгт 17.	Завсарын зардал /мянган төгрөг/	19
Хүснэгт 18.	Үйл ажиллагааны бус зардлын тооцоо /мянган төгрөг/	20
Хүснэгт 19.	Хүний нөөцийн хөгжил хөтөлбөр	21
Хүснэгт 20.	Мэргэшүүлэх сургалт	22
Хүснэгт 21.	Мэргэжил дээшлүүлэх сургалт	22
Хүснэгт 22.	2022 онд зохион байгуулагдах үйл ажиллагаанууд	23
Хүснэгт 23.	2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт	25



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

Ерөнхий танилцуулга

Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн нь анх 1964 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор “Барилга засвар, шугам сүлжээний зураг төсвийн групп” нэртэйгээр байгуулагдсан бөгөөд өнгөрсөн 55 жилийн хугацаанд нэршил нь 10 удаа өөрчлөгдөн хамгийн сүүлд Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 116 дугаар тогтоолоор “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ болж өөрчлөгдөн дүрэм нь батлагдсан.

Байршил: Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо, Яармаг, Шинэ захиргааны байр, Б блок, 9 дүгээр давхар

Удирдлага: Раднаагийн Амартүвшин нь Нийслэлийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 10-ний өдрийн Б/60 дугаар захирамжаар Хот төлөвлөлт, судалгааны Институтын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж байна.

Бүтэц орон тоо: Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн А/312 тоот захирамжаар 8 хэлтэс, 81 хүртэл орон тоотой болж өөрчлөгдөн батлагдсан байна.

Цахим хаяг: info@upri.ub.gov.mn

Вэб хаяг: www.upri.ub.gov.mn

Тус институтын үйл ажиллагааг зохицуулагч хууль эрх зүйн үндсэн баримт бичиг нь

- Иргэний тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль,
- Хот байгуулалтын тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Зохиогчдын эрх болон түүнийг хамгаалах эрхийн тухай хууль,
- Газрын тухай хууль,
- Авто замын тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Нийслэлийн Иргэдийн Хурлын тогтоол,
- Нийслэлийн Засаг даргын захирамж, үйл ажиллагааны хөтөлбөр байна.



Бүтэц зохион байгуулалтын ерөнхий схем

Зураг 1. Бүтцийн схем



Хүснэгт 1. Батлагдсан орон тоо

№	Албан тушаал		Батлагдсан орон тоо	Нийт орон тоо
Нэг. Удирдлага				
1	Дарга		1	3
2	Ерөнхий инженер		1	
3	Ерөнхий менежер		1	
Хоёр. Захиргаа, удирдлага санхүүгийн хэлтэс				
4	Хэлтсийн дарга		1	14
5	Ахлах мэргэжилтэн		2	
6	Мэргэжилтэн		11	
Гурав. Хот төлөвлөлтийн хэлтэс				
14	Хэлтсийн дарга		1	10
15	Ахлах мэргэжилтэн		2	
16	Мэргэжилтэн		7	
Дөрөв. Дэд бүтцийн хэлтэс				
20	Хэлтсийн дарга		1	9
21	Ахлах мэргэжилтэн		1	
22	Мэргэжилтэн		7	
Тав. Эдийн засаг, судалгааны хэлтэс				
27	Хэлтсийн дарга		1	13
28	Ахлах мэргэжилтэн		2	
29	Мэргэжилтэн		10	
Зургаа. Архитектур, төлөвлөлтийн хэлтэс				
32	Хэлтсийн дарга		1	8
33	Ахлах мэргэжилтэн		1	
34	Мэргэжилтэн		6	
Долоо. Хотын дизайны хэлтэс				
40	Хэлтсийн дарга		1	6
41	Ахлах мэргэжилтэн		1	
42	Мэргэжилтэн		4	



		Найм. Хяналт мониторингийн хэлтэс		
43	Хэлтсийн дарга		1	6
44	Ахлах мэргэжилтэн		1	
45	Мэргэжилтэн		4	
		Ес. Зам тээвэр, судалгаа төлөвлөлтийн хэлтэс		
46	Хэлтсийн дарга		1	12
47	Ахлах мэргэжилтэн		1	
48	Мэргэжилтэн		10	
НИЙТ			81	81



ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ

Эрхэм зорилго, чиг үүрэг, алсын хараа, үнэт зүйл, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Эрхэм зорилго: Түүх, соёл иргэншлийн уламжлал, бүсчилсэн хөгжлийн бодлого, хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн нийслэлийн хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэхийн тулд хот төлөвлөлтийн суурь судалгаа хийх, бүс нутаг, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн зураг, төсөл боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлж Хотын удирдлага, хот байгуулалтын салбарын байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг олон улсын жишигт нийцсэн хот төлөвлөлтийн эрдэм, шинжилгээ, судалгааны ажил, зураг төслөөр хангахад оршино.

Чиг үүрэг: Эрхэм зорилгоо хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд хот төлөвлөлтийн суурь судалгааг хийх, хот байгуулалтын баримт бичгийг боловсруулах, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, ойрын болон тухайн жилийн эдийн засгийн нийгмийн зорилтод тусгагдсан ерөнхий төлөвлөгөө, барилга, байгууламж, инженерийн дэд бүтцийн болон авто зам, гүүрний зураг төсөл болон бусад ТЭЗҮ, төсөл хөтөлбөр боловсруулах зэрэг үйл ажиллагааг эрхэлнэ.

Алсын хараа: Эрдэм шинжилгээ, тооцоо судалгаанд тулгуурласан олон улсад өрсөлдөх чадвартай Хот төлөвлөлт, судалгааны институт болох

Үнэт зүйл: Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай, мэргэшсэн, чадварлаг, зарчимч боловсон хүчин

Удирдлагын манлайлал: Байгууллагын хөгжлийн ирээдүйн хандлагыг тодорхойлогч, бусдыг үлгэрлэн дагуулж, урам зориг, итгэл үнэмшлийг бадраах, бататгах, бодит үр дүнд хүрэх чадварыг бид үнэт зүйлс гэж үзнэ.

Чин сэтгэл: Асуудлыг бүтээлчээр илрүүлж, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, төгөлдөршүүлэхийн төлөө тууштай зүтгэл мэргэжлийн өндөр түвшин, оновчтой санал, санаачилгыг бид үнэт зүйлс гэж үзнэ.

Үнэнч шударга байдал: Хууль тогтоомжийг дээдлэн эрхэлсэн ажилдаа үнэнч шударга, өөриймсөг ханддаг сэтгэл, зүтгэлийг бид үнэт зүйлс гэж үзнэ.

Хамт олны нэгдмэл шинж чанар: Хамт олон бие биеэ харилцан хүндэтгэх, дэмжин туслах, итгэл, найдварыг даах, нэгдсэн санал, санаачилга, хүчин чармайлтыг бид үнэт зүйлс гэж үзнэ.

Үр нөлөөтэй хяналт: Дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн ажлын явц, гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг байнга үнэлж дүгнэж ажиллах чадварыг бид үнэт зүйлс гэж үзнэ.

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл: Нийслэл Улаанбаатар хотын нийгэм, эдийн засгийн хөгжилд хамаарах, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, ойрын болон тухайн жилийн эдийн засгийн нийгмийн зорилтод тусгагдсан ерөнхий төлөвлөгөө, барилга, байгууламж, инженерийн дэд бүтцийн болон авто зам, гүүрний зураг төсөл болон бусад ТЭЗҮ, төсөл хөтөлбөр боловсруулах

Үйл ажиллагааны чиглэл: Эрхэм зорилгоо хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг эрхэлнэ.

- ✓ Хот төлөвлөлтийн суурь судалгааг хийх
 - Газар нутаг, хүн амын,
 - Эдийн засаг, хөрөнгө оруулалтын судалгаа
 - Нийгэм, соёлын судалгаа
 - Зам тээвэр, инженерийн дэд бүтцийн судалгаа
 - Байгаль орчин, аюулгүй байдлын судалгаа
 - Газар ашиглалт, барилгажилтын судалгаа



- Шаардлагатай бусад судалгааг хийх
 - ✓ Хот байгуулалтын баримт бичгийг боловсруулах
 - Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл,
 - Бүсийн хөгжлийн төсөл,
 - Чөлөөт бүс, аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө
 - хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
 - хот тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
 - шинэ хороолол, бичил хорооллын төлөвлөгөө
 - барилга байгууламжийн зураг төсөл
 - хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
 - хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл
 - ✓ Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, ойрын болон тухайн жилийн эдийн засаг нийгмийн зорилтод тусгагдсан ерөнхий төлөвлөгөө, барилга, байгууламж, инженерийн дэд бүтцийн болон авто зам, гүүрний зураг төсөл болон бусад ТЭЗҮ, төсөл хөтөлбөр боловсруулах
 - ✓ Улсын Их Хурлын 2025 оны дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэл Улаанбаатар хотын 204 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө "хот төлөвлөлтийн баримт бичгийн ерөнхий зохиогчийн хувьд тус ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа явцад мониторинг хийж, биелэлтийг хоёр жил тутам гаргаж, Улсын Их Хуралд танилцуулах ажлын хэсэгт оролцож ажиллах ба түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх салбаруудын мастер төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл, хот байгуулалтын төсөл, хөтөлбөр боловсруулах, ерөнхий болон ХЕТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх
 - ✓ Хот байгуулалт, төлөвлөлт, барилга байгууламжийн төрөл бүрийн асуудлуудыг шийдвэрлэх эрдэм шинжилгээний суурь болон дагалдах хавсралт судалгаа, шинжилгээний төслүүд, техник эдийн засгийн үндэслэл боловсруулсны үндсэн дээр хэтийн болон дунд хугацааны хөгжлийн менежментийн төлөвлөгөө, төсөл хөтөлбөр боловсруулж, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх
 - ✓ Төрийн болон гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь иргэний захиалгаар хот, тосгодын ерөнхий төлөвлөгөө, ХЕТ, барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн болон авто зам, гүүрний зураг төсөл боловсруулах зэрэг зураг төслийн байгууллагын хийж гүйцэтгэдэг нийтлэг үйл ажиллагааг эрхлэх
 - ✓ Дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар боловсруулсан хот байгуулалтын төсөл, хөтөлбөр, улс хотын чанартай томоохон барилга, байгууламжийн зураг төсөлд ерөнхий төлөвлөгөөний хүрээнд санал дүгнэлт өгөх
 - ✓ Хот байгуулалт, төлөвлөлттэй холбоотой дүрэм, журам, норм, стандарт шинээр боловсруулах болон өөрчлөлт, шинэчлэлт оруулах санал боловсруулах
 - ✓ Нийслэлийн хөгжлийн хэтийн төлөв, бүс нутгийн онцлогт нийцсэн нутаг дэвсгэрийн өсөлтийн менежмент, тэнцвэртэй хөгжил ба улс, бүс доторх хамтын ажиллагаа болон улс хоорондын хамтын ажиллагааны стратегийн санал боловсруулах
 - ✓ Дотоод, гадаадын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдыг татах, сургалт, судалгаанд зориулж өөрсдийн гүйцэтгэсэн ажлаар бүх төрлийн сурталчилгаа явуулах, ном, товхимол хэвлэх, үзэсгэлэн гаргах, онол практикийн хурал, зөвлөгөөн хийх ажлыг зохион байгуулах
- Бүтээгдэхүүн үйлчилгээ - Бүтээгдэхүүн үйлчилгээний жагсаалт:
- Хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө



- Эрдэм шинжилгээний ажил /Хот төлөвлөлт, сэргээгдэх эрчим хүч, бие даасан дулаан, цахилгааны эх үүсвэрүүд/
- Барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, /Үүнд: Иргэдэд зориулан төвийн халаалттай орон сууц болон амины орон сууцны зураг төсөл гэх мэт/
- Олон улсын байгууллага, гадаад орны засаг захиргаа, бизнесийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зураг төсөл, хот төлөвлөлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах



ГУРАВДУГААР БҮЛЭГ: 2025 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт нэг: Борлуулалтын орлогыг өмнөх оны зорилтоос бууруулахгүй байх

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 111 дүгээр “Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолоор батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнээс байгууллагын чиг үүргийн дагуу гүйцэтгэж болохуйц төсөл, арга хэмжээний санхүүжилтэд тулгуурлан 2025 оны үйл ажиллагааны орлогын хэмжээг тооцоолон төсөвлөж борлуулалтын орлогыг өмнөх оны төлөвлөлтөөс 25 гаруй хувиар өсгөж 8.7 тэрбумаар төлөвлөж орлогыг бууруулахгүй байх зорилтыг тавьж ажиллахаар төлөвлөж байна.

Борлуулалтын орлогын хувьд нийт 8.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 75 орчим хувийг Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээ, Нийслэлийн Засаг даргын үүрэг даалгавар /захирамж/-ын хүрээнд хийгдэх ажлын хүрээнд, нийслэлийн 10 орчим хувийг нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх судалгааны хэлтсийн албан хаагчдын цалин, 15 орчим хувийг яамдууд, нийслэлийн худалдан авах ажиллагааны газар, хөдөө орон нутагт хийгдэхээр төлөвлөсөн хот төлөвлөлт, барилга байгууламжийн зураг төслийн ажлын тендерийн сонгон шалгаруулалтад оролцох замаар бүрдүүлэх, Зохиогчийн хяналт болон бусад орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн.

Зорилт хоёр: Цэвэр ашгийн түвшинг өмнөх оны төлөвлөлтөд дүйцүүлэх

Ашгийн хувьд өмнөх оны төлөвлөлтийн дүнгээс бууруулахгүй 4 хувийн өсөлттэй байх зорилтыг дэвшүүлсэн. Байгууллагын үйл ажиллагааны хүрээг тэлж орлогыг нэмэгдүүлэх зорилгоор тусгай зөвшөөрлийг авахад шаардагдах тоног төхөөрөмжийн эхний урьдчилгааны зардлууд ажилчдын нийгмийн хэрэгцээг хангах үүднээс байгууллагын зуслангийн газар дээр төлөвлөлт хийх, ажилтнуудад олгох ажлыг зохион байгуулах зэргээс хамаарч зардал өмнөх оны зорилтоос нэмэгдэнэ гэж таамагласан. Зардал нэмэгдэж буй учир борлуулалтын орлогыг мөн нэмэгдүүлсэн.

Зорилт гурав: Хүний нөөцийн хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Институтийн зорилтын хүрээнд хүний нөөцийг сургах, хөгжүүлэх, хуваарилах, мэргэшсэн ажилтнуудыг сонгох, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах асуудлыг шийдвэрлэж, чадварлаг мэргэшсэн хүний нөөц бүхий мэргэжлийн байгууллага бий болоход чиглэгдсэн хөтөлбөр юм.

Институтийн үнэт зүйл нь мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай, мэргэшсэн, чадварлаг, зарчимч боловсон хүчин тул 2025 онд ажилтан, албан хаагчдынхаа өмнө хүлээх хариуцлагаа нэмэгдүүлж ажлын байрыг хадгалж, тогтворжуулах үүднээс хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, орон байраар хангахад туслах, зуслангийн байртай болгох, шаардлагатай сул орон тоог нөхөх замаар ажлын ачааллыг бууруулах, албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх, цалингийн хэмжээг нэмэгдүүлэх, байгууллагын уур амьсгал, соёлыг дээшлүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөв.

- Хүний нөөц хөгжил, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг ISO 9001 Чанарын удирдлагын тогтолцоотой уялдуулан шинэчлэн боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангах;

- Хүний нөөцийн сургалтыг ISO 9001 Чанарын удирдлагын тогтолцоотой уялдуулан батлагдсан үнэлэмжийн дагуу авсан судалгаан дээр үндэслэн төлөвлөж хэрэгжилтийг хангаж ажиллах;



Гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг БНСУ-ын Сөүл Институт, БНХАУ-ын ӨМӨЗО-ны нийслэл Хөх хотын зураг төслийн хүрээлэн, Шанхай хотын ногоон байгууламж төлөвлөлтийн ерөнхий хүрээлэн ХХК, Зүүн хятадын архитектур төлөвлөлт судалгааны хүрээлэн ХХК-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах, туршлага солилцох

Зорилт дөрөв: Чанарын менежментийн тогтолцооны ISO:9001 стандартыг хэрэгжүүлэн нутагшуулах, хэрэгжилтийг хангаж хэвшүүлэх.

Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа журмуудыг "Төрийн хэмнэлтийн тухай хууль" болон ISO 9001 чанарын удирдлагын тогтолцооны хүрээнд шинээр боловсруулж баталсан 37 журмын хэрэгжилтийг хангаж хэвшүүлэх;

– ISO 9001 Чанарын удирдлагын тогтолцооны хүрээнд жилд 2 удаа дотоод аудитыг хийж үр дүнг тогтмол хянан цаашид сайжруулах ажлыг зохион байгуулна;

– Байгууллагын ЧМТ-ны хүрээнд мөрдөх 34 дотоодын шинжтэй баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулж, код тэмдэглэгээ олгон, тогтолцооны хүрээн дахь нэгдсэн жагсаалтад хамруулах;

ЗОРИЛТ НЭГ: БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫГ ӨМНӨХ ОНЫ ЗОРИЛТООС БУУРУУЛАХГҮЙ БАЙХ

нийт 8.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 75 орчим хувийг Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээ, Нийслэлийн Засаг даргын үүрэг даалгавар /захирамж/-ын хүрээнд хийгдэх ажлын хүрээнд, нийслэлийн 15 орчим хувийг нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх судалгааны хэлтсийн албан хаагчдын цалин, 10 орчим хувийг яамдууд, нийслэлийн худалдан авах ажиллагааны газар, хөдөө орон нутагт хийгдэхээр төлөвлөсөн хот төлөвлөлт, барилга байгууламжийн зураг төслийн ажлын тендерийн сонгон шалгаруулалтад оролцох замаар бүрдүүлэх, Зохиогчийн хяналт болон бусад орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1370 дугаар захирамжийн дагуу "“Буянт-Ухаа спорт цогцолбороос Торгоны зам цогцолбор, 120 мянгатын уулзвараас Сүхбаатарын талбай чиглэлд тусгай замын автобус (BRT) нэвтрүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах", "Уулзваруудын нэвтрэх чадварыг сайжруулах талаар техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах", "“Зуслангийн бүсийг хотын төвийн бүстэй холбох хөнгөн галт тэрэг (LRT) нэвтрүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэл, загвар зураг төсөв боловсруулах" ажил, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1189 дугаар захирамжийн дагуу "Нийслэл Улаанбаатар хотын 204 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" ажил, болон бусад зохиогчийн хяналт, барьцаа, тендерт оролцох зэргээр нийт 8.7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого бүрдүүлэн ажиллахаар төлөвлөсөн болно.

Хүснэгт 2. Борлуулалтын төлөвлөгөөний биелэлт, сая төг

№	Ажлын төрөл	Санхүүжилт	Төсөв	Тайлбар
1	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээнээс олох орлого			



1.1	Улаанбаатар “20 минутын хот” буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлого, төлөвлөлтийг боловсруулж, төвлөрлийг задлан шинээр байгуулагдах 14 хот, 42 нэгж хорооллыг хөгжүүлж, иргэд өөрийн оршин суух газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ	НТөсөв	15,220.4	НЗД-ын захирамж	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зохиогчийн эрх Дундын шатны тайлан хүртэлх ажлыг хийж гүйцэтгэсэн
1.2	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1370 дугаар захирамжийн дагуу “Буянт-Ухаа спорт цогцолбороос Торгоны зам цогцолбор, 120 мянгатын уулзвараас Сүхбаатарын талбай чиглэлд тусгай замын автобус (BRT) нэвтрүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах”, “Уулзваруудын нэвтрэх чадварыг сайжруулах талаар техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах”, “Зуслангийн бүсийг хотын төвийн бүстэй холбох хөнгөн галт тэрэг (LRT) нэвтрүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэл, загвар зураг төсөв боловсруулах” ажил	НТөсөв	7,000.0	НЗД-ын захирамж	
1.3	“Яармаг” хотын шинэ төв буюу 27 дугаар нэгж хорооллын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг)	НТөсөв	208.3		
1.4	Дүрмийн 8.1.2 дагуу Зохиогчийн хяналт, бусад орлого		125.0		
БОЛОМЖИТ ОРЛОГО (нийт орлогын 38% иар тооцов)			7,873.3		
3	Нийслэлийн төсвөөс санхүүжих				
3.1	Дүрмийн 8.1.1. дагуу судалгааны ажилчдын цалингийн санхүүжилт		909.0		
НИЙТ БОРЛУУЛАЛТЫН ДҮН			8,782.24		

ЗОРИЛТ ХОЁР: ЦЭВЭР АШГИЙН ТҮВШИНГ ӨМНӨХ ОНЫ ТӨЛӨВЛӨЛТӨД ДҮЙЦҮҮЛЭХ

2024 онд цэвэр ашгийг 141,5 сая төгрөгөөс доошгүй байлгах зорилт тавьж ажилласан. 2025 онд мөн цэвэр ашгийг өмнөх оны зорилтод дүйцүүлэх буюу **140.3 сая төгрөг** байх зорилт тавин ажиллахаар төлөвлөв.

Нийслэлийн Засаг Даргын 2025 оны 06 дугаар сарын 27 ны өдрийн “Эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин батлах тухай” А/921 дугаар захирамжаар байгууллагын 2025 оны нийт орлогыг 8,349,210.2 мянган төгрөг, зардлыг 8,175,493.2 мянган төгрөг, цэвэр ашгийг 173,717.0 мянган төгрөг, борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардлыг 0,96 төгрөг, тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 476,002.3 мянган төгрөг байхаар баталсан.

Хүснэгт 3. 2025 оны бизнесийн төлөвлөгөөний төсөл /мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2024 он		2025 он	
		Төлөвлөлт	2024.12.31 хүлээгдэж буй	Байгууллагын санал	эзлэх хувь
1.1	Борлуулалтын орлого	3,837,165.1	5,351,809.9	7,440,247.4	89.1%
1.2	Нийслэлийн төсвөөс	908,962.8	765,239.0	908,962.8	10.9%
1	Нийт орлогын дүн	4,746,127.9	6,117,048.9	8,349,210.2	100%



2.1	ББӨ	725,582.8	1,980,122.7	2,318,511.5	28.8%
2.2	Цалин, нэмэгдэл	2,126,346.4	2,179,927.7	3,221,546.3	40.0%
2.3	Хоол,унаа	357,840.0	323,517.6	518,595.0	6.4%
2.4	НДШ	265,793.3	326,669.0	467,517.7	5.8%
2.5	Түрээс, ашиглалт	52,100.0	54,258.2	95,079.2	1.2%
2.6	Албан томилолтын зардал	176,000.0	122,807.0	227,000.0	2.8%
2.7	Элэгдлийн зардал	132,872.1	123,120.0	139,549.4	1.7%
2.8	Түүхий эд материалын зардал	73,500.0	108,609.4	175,644.8	2.2%
2.9	Зар сурталчилгааны зардал	36,850.0	78,154.2	113,050.0	1.4%
2.10.	Сургалтын зардал	49,320.0	50,441.3	106,069.0	1.3%
2.11	Эрдэм шинжилгээ	83,580.0	67,230.8	118,580.0	1.5%
2.12	Шуудан холбооны зардал	15,782.0	11,088.0	15,782.0	0.2%
2.13	Тээврийн зардал	27,889.2	29,249.0	29,955.6	0.4%
2.14	Засварын зардал	51,400.0	65,717.9	81,950.0	1.0%
2.15	УЗ-н зардал	44,550.0	29,810.0	84,510.0	1.0%
2	Үйл ажиллагааны зардал	4,219,405.8	5,550,722.7	7,713,340.5	96%
3	Үйл ажиллагааны бус зардал	158,300.0	129,081.9	335,832.00	4.2%
4	Нийт зардал	4,377,705.8	5,679,804.7	8,049,172.5	100%
5	Татвар төлөхийн өмнөх ашиг	157,186.5	437,244.2	300,037.7	4%
6	Татварын зардал	15,718.7	65,426.5	126,320.75	2%
7	Цэвэр ашиг	141,467.8	371,817.7	173,717.0	2%
8	БОНТНЗ	0.95	0.93	0.96	
9.1	Авлага	407,241.0	467,053.2	366,516.9	10%
9.2	Өглөг	167,023.7	203,602.0	150,321.3	10%
10	Хөрөнгө оруулалт /Өөрийн хөрөнгөөр/	353,953.4	342,033.7	476,002.3	
11	Орон тоо	81	58	82	

1. Зардлын задаргаа

2025 оны зардлыг ангилал тус бүрээр гаргаж үйл ажиллагааны зардалд 7,7 тэрбум төгрөг, үйл ажиллагааны бус зардалд 335,8 сая төгрөг нийт зардлыг 8.0 тэрбум байхаар төлөвлөсөн.

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил дуусаж, баталгаажуулах шатанд явж байгаа тул олон түмэнд танилцуулах, мэдээллийг хуваалцах зэрэг зар сурталчилгаа болон ерөнхий төлөвлөгөөний боть хэвлүүлэхтэй холбоотойгоор эрдэм шинжилгээний зардал нэмэгдсэн.

Хүснэгт 4. 2025 онд төлөвлөсөн зардлын нэгдсэн хүснэгт /мянган төгрөг/

Д/д	Үзүүлэлт	Зардлын дүн	Эзлэх хувь
2.1	ББӨ	2,318,511.5	27.2%
2.2	Цалин, нэмэгдэл	3,221,546.3	43.1%
2.3	Хоол,унаа	518,595.0	6.1%
2.4	НДШ	467,517.7	6.1%



2.5	Түрээс, ашиглалт	95,079.2	1.1%
2.6	Албан томилолтын зардал	227,000.0	2.7%
2.7	Элэгдлийн зардал	139,549.4	1.7%
2.8	Түүхий эд материалын зардал	175,644.8	2.1%
2.9	Зар сурталчилгааны зардал	113,050.0	1.2%
2.10.	Сургалтын зардал	106,069.0	0.9%
2.11	Эрдэм шинжилгээ	118,580.0	1.4%
2.12	Шуудан холбооны зардал	15,782.0	0.2%
2.13	Тээврийн зардал	29,955.6	0.3%
2.14	Засварын зардал	81,950.0	0.8%
2.15	УЗ-н зардал	84,510.0	1.0%
2	Үйл ажиллагааны зардал	7,713,340.5	96.1%
3	Үйл ажиллагааны бус зардал	335,832.00	3.9%
4	Нийт зардал	8,049,172.5	

1.1 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

2025 оны ББӨ-г урьд оны гүйцэтгэлтэй харьцуулж борлуулалтын орлогын (НӨАТ-тай үнийн дүнгийн) 26% хувиас хэтрүүлэхгүй байхаар төсөвлөв. Ажилчдыг чадавхжуулж, орон тоог нэмснээр туслан гүйцэтгэгч авахтай холбоотой зардал багасна. Нийт үйл ажиллагааны зардлын 27% ББӨ-ний зардал байна.

Хүснэгт 5. ББӨ /мянган төгрөг/

№	Зардлын нэр	Дүн	Эзлэх хувь
1	Байр зүйн дэвсгэр зураг	463,702.3	20%
2	Хөрсний инженер геологийн судалгаа, дүгнэлт	579,627.9	25%
3	Байгаль орчны ерөнхий, нарийвчилсан үнэлгээ	231,851.1	10%
4	Магадлалын зардал	394,147.0	17%
5	Нарийн мэргэшил, мэдлэг шаардсан ажлуудад туслан гүйцэтгэгч, Зөвлөх гэрээгээр ажиллуулах ажлын хөлс	231,851.1	10%
6	Томоохон ажлуудад түншилсэн түншлэлийн хөлс	231,851.1	10%
7	Бусад /Техникийн нөхцлийн тодруулга гэх мэт/	185,480.9	8%
	Нийт дүн	2,318,511.5	100%

1.2 Цалингийн зардал

Цалингийн зардлын хувьд 2025 онд хэлтэс тус бүрээс ирсэн саналыг харгалзан үзэж шаардлагатай орон тооны ажилчдыг авч нийт 82 ажилтантаны орон тоотой боловч бодит байдалд 60-70 албан хаагч байнгын ажиллаж байгаа тул 72 ажилтанаар тооцож 3,7 тэрбум төгрөгийн зардал төсөвлөсөн. Нийт үйл ажиллагааны зардлын 43.8 хувь нь цалин, хоол унааны зардал болно. Тус институтийн үйл ажиллагааны онцлог нь зөвлөх үйлчилгээ үзүүлдэг оюуны өмчийн ажил хийдэг учир ажилчдын ачаалал их үүнээс үүдэн цалингийн зардал ихэнх хувийг эзэлнэ.

Хүснэгт 6. Нийт ажилчдын цалингийн батлагдсан төсөв /төгрөг

№	Албан тушаал	Үндсэн цалин	Жилийн үндсэн цалин	Нэмэгдлүүд				нийт дүн / нийт
